



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 1А/80

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1 дэх хэсэг, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сэц мэлмий ХХК-ийн “Шинэ өглөө” зочид буудлын 19/381, Алтан янзага ХХК-ийн “Рич хилл” зочид буудлын 19/392, Батхаан групп ХХК-ийн “Батхаан” зочид буудлын 19/410, Цогт өргөө од ХХК-ийн “Цогтбаян” зочид буудлын 19/400, Элкс трейд ХХК-ийн “Элкс” дэн буудлын 19/394, Эрмон билэг ХХК-ийн “Эрмон” дэн буудлын 19/413, Зуно ХХК-ийн “Генерал” дэн буудлын 19/384 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Р.Батням/-т үүрэг болгосугай.

1150500286

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/- д үүрэг болгосугай.

6. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай.

ДАРГА



С.БАТБААТАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 11
сарын 02-ны өдрийн А/80 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Сэц мэлмий ХХК	5195411	Шинэ өглөө	БГД-ийн 5-р хороо, 10-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө 83/01 тоот
2	Алтан янзага ХХК	5473219	Рич хилл	БГД-ийн 7-р хороо, 4-р хороолол, Дилав хутагт Жамсранжавын гудамж 51 тоот
3	Батхаан групп ХХК	2027968	Батхаан	БГД-ийн 1-р хороо, Замчдын гудамж 37
4	Дэлгэр хур трейд ХХК	2858673	Мичид 2	БГД-ийн 3-р хороо, Дангийн 146 байр
5	Цогт өргөө од ХХК	2857405	Цогтбаян	СБД-ийн 11-р хороо, Цагдаагийн гудамж 43
6	Их баяннуур ХХК	2069385	Өнөр	СХД-ийн 13-р хороо, Өнөр төвийн байр

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 11 сарын
02-ны өдрийн А/80 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ 4-8926 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Элкс трейд ХХК	2110318	Элкс	ХУД-ийн, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө
2	Усам ХХК	6312705	Секрит	БГД-ийн 22-р хороо, Зүүннаран 18/37 тоот
3	Эрмон билэг ХХК	5021146	Эрмон билэг	БГД-ийн 17-р хороо, 4-р хороолол Эрмон билэг байр
4	Зуно ХХК	2732394	Генерал	БЗД-ийн 16-р хороо, Дандарбаатарын гудамж 20

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР